

Дэлхий дээрх монголчуудын дийлэнх нь БНХАУ, Монгол улс, ОХУ-д амьдардаг бөгөөд тэдний нутаглан буй газар нутаг нь олон зууны турш монгол үндэстний идээшин тархсан өвгөд дээдсээсээ уламжлан ирсэн газар билээ. БНХАУ, ОХУ дахь монголчууд газар нутагтаа тус улсын ямар нэг засаг захиргааны субъектын хэлбэрээр оршин байгаа юм. Үүнд: ОХУ-ын бүрэлдэхүүнд багтах бүгд Найрамдах Улс, автономит тойрог БНХАУ-д өөртөө засах орон, өөртөө засах тойрог, өөртөө засах саянь болно. Өнөөдөр бидэнд ОХУ, БНХАУ дахь монголчуудын үүх түүх болон өнөөгийн байдал нэн сонирхолтой асуудал юм. Түүхийн нилээд урт хугацааны турш саланги тусдаа явж ирсний улмаас монголчууд бие биенийхээ тухай тун ч бүрхэг ойлголттой явж ирсэн байдлаас ангижрах нь үндэсний ухамсарт ач холбогдолтой. Буриад болон Өвөр Монголчууд Монгол орны талаар тун ч тааруухан ойлголттой байдгийн адил бид ч тэдний талаар Хятаджсан, оросжсон гэдгээс өөр ойлголтгүй шахам явж ирлээ. Ялангуяа хүүхэд залуучуудын дунд тэднийг өөр үндэстэн мэт ойлгох явдал түгээмэл болжээ. ДДОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд “Орос дахь монгол угсааны утсууд” гэдэг ном бичиж саяхан хэвлүүлэн худалдаж байна. Энэ бол манайд анх удаа Орос дахь монгол угсааны улсуудын тухай цогц хэлбэрээр бичсэн ном боллоо. Түүний өмнөх үгт: “Өнөөдөр манай Монгол улс хүн торолхтний орчин үеийн соёл иргэншлийн дэвшлээс сурч, үндэстнээ өв тэгш сэргээн мандуулах бодлого тууштай явуулж байгаа тул хөрш орнууд дахь монгол угсаатантайгаа аль болохоор ойртож, тэдгээрийн өөрчлөлт шинэчлэлийн туршлагатай танилцаж, харилцан үр ашигтай хамтран ажиллах явдал зүй ёсны шаардлага болж байна” гэж тэмдэглээд: “... Бидний толилуулан буй ном бол анхны ажил учраас лавшруулан хийх цаашдын судалгааны удиртгал юм” гэжээ. Энэ номд ОХУ-ын Монгол угсаатан, ус, тойргуудын хүн амын гарал бүрэлдэхүүн, түүхэн тойм. Нийгэм-эдийн засгийн байгуулал, соёл гэгээрэл болон тэдгээр улсууд ба Монгол улсын хоорондын харилцааны талаар бичсэн байна. Энэ ном БНБуриад Улс, Буриадын автономит тойргууд, БН Халимаг Тангч Улс, БН Тува Улс, БНАлтай Улс гэсэн 5 бүлэгтэй ба эхний хоёрыг эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батцэцэг, дараагийн 3 бүлгийг эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, гүн ухааны доктор А.Нямаа бичжээ.

Эхний бүлэгт өгүүлсэн Бүгд Найрамдах Буриад Улс бол эдгээр улсууд дотроос хамгийн том нь билээ. Зохиогч буриад-монголчуудын түүхийг 5 зүйлээр ангилан үзэж тус бүрд нь дэд гарчиг гарган тодорхой өгүүлэхдээ сүүлийн үед хэвлэгдсэн ном, хэвлэлийг ашиглан нэлээд шинэлэг байдлаар хандсан нь эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм. Тухайлбал буриад нутаг Хаант Оросын харъяанд орсон асуудлыг буриадууд Орост сайн дураар дагаар орсон гэх юм уу, эсвэл оросууд зөвхөн зэвсгийн хүчээр түрэмгийлж эзэлсэн гэж дүгнэх нь аль аль нь өрөөсгөл болох бөгөөд, учир нь буриадын олон овог аймгууд, тэдний

ноёдын хооронд нэгдсэн бодлогогүй нэг хэсэг нь оросуудыг аялдан дагах байдалтай байсныг бичсэн байна. (т.24), Зөвлөлт засгийн жилүүдэд буриад зон хэлмэгдүүлэлтийн хар шуурганд хамгийн их өртсөн ард түмний нэг билээ. Үндэстний шилдэг охид хөвгүүд, тэргүүний сэхээтнүүд ардын дайсан, Японы тагнуул, үндсэрхэг үзэлт зэрэг нэр хоч зүүж өгүүтгэгдсэн нь өнөө ч буриадын ард түмний аниагүй сэтгэлийн шарх ажгуу. Басхүү соёлын бүтээн байгуулалтад орсон амжилтыг бичихийн хамт, үндэсний соёлын өв уламжлал, ёс заншлыг боогдуулсны улмаас эх хэлээ мэдэхгүй буриадуудын бүхэл бүтэн үе эхэлж, улмаар буриад үндэснийхээ соёлын бүтээн байгуулалтад оролцох боломжгүй болсныг дурьдалгүй өнгөрсөнгүй. Цааш нь “Буриад дахь өөрчлөлт-шинэчлэлт”, “Монгол Буриад улсын эрт эдүгээгийн харилцааны тойм” хэсгүүдээ зохиогч сүүлийн үеийн шинэ тутам мэдээ материал, тоо баримт ашиглаж бичсэн нь нэн олзуурхууштай боллоо. Ялангуяа зах зээлд шилжиж буй үеийн Эдийн засгийн байдал, бодлогыг ямар нэг хэмжээгээр танилцуулсан нь хөрш оронтойгоо харилцаагаа өргөжүүлэхэд манай ажил хэрэгч хүмүүст тустай болов уу. Номын 2 дахь бүлэг нь “ОХУ дахь Буриадын автономит тойргууд” нэртэй. Зохиогч эдгээр тойргууд 1937 оны ЗХУ ын Төвийн Гүйцэтгэх Хорооноос Буриад-Монголыг хэсэгчлэн хуваах зүй бус тогтоолын үр дүнд үүссэн бөгөөд буриадын ард түмэн нутаг дэвсгэрээрээ хүртэл хэлмэгдсэнийг дурьджээ. (т.52) Мөн Буриадын БНУ-ын гадна амьдарч буй буриадууд нийт үндэсний амьдралаас тасарч, үндэсний хэл соёлоо хөгжүүлэхэд оролцох боломжгүй болж, төрөлх хэлээ мартахад хүрсэнийг өгүүлсэн байна. (т. 52).

Харин ЗХУ өөрийн сэдсэн өөрчлөлт шинэчлэлийнхээ явцад задран мөхсөн үед эдгээр тойрогт буй буриадуудын үндэсний соёл сэргэж. БНУ-тай харилцаагаа өргөжүүлж байгаа юм байна. Монгол улсын Архангай аймаг-Усть Ордын Буриадын автономит тойрог, Хэнтий, Дорнод аймгууд-Агын буриадын автономит тойрогтой шууд харилцаа тогтоож, эдийн засаг, соёлын салбарт хамтран ажиллаж байгааг бичжээ. (т.53-55)

Гурав дахь бүлэг Бүгд Найрамдах Халимаг-Тангч Улсын тухай өгүүлэх агаад эхлээд “Халимагийн гарваль нүүдэл”, “Халимагийн түүхэн тойм” хэсгүүдээ зохиогч чухал түүхэн бүтээл, архивын материал ашиглан бичсэн нь цаашдын судлаачдад ч чухал тус болохуйц дорвитой болсон байна. Тухайлбал, ХХ зууны Халимгийн Зөвлөлт засгийн үед болсон гунигт явдлууд болох иргэний дайны жилүүдэд. 100 гаруй мянган халимаг хүн амь үрэгдсэн, 1943 оны ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн зарлигаар ЗСБНАХалимаг Улсыг устгасан ба 100 гаруй мянган халимаг хүнийг төрөлх нутгаас нь салгаж Сибирийн мужуудад таархан цөлсөн зэргийг бичсэнийг дурьдууштай. (т.66-67) Дээрх 1945 оны зарлигийг ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1989 оны 11 сарын 14-ний тунхаглалд хүчингүй болгожээ. (т.69) “Халимгийн хүн ам”. “Нийгэм-эдийн засгийн байгуулал” хэсгүүдэд сүүлийн үеийн тоо баримт, материал ашигласан байна. Халимаг улсын хүн амын талаас илүү нь халимаг бөгөөд үүнээс гуравны хоёр нь торгууд, бусад нь дөрвөд, хошууд ястан Ж. (т.69) Зохиогч мөн Халимагийн улс төрийн байдлын талаар товч бичжээ. Хамгийн эдийн засгийн үндэс нь мал аж ахуй боловч, газар тариалан, аж үйлдвэр хөгжсөн болохыг өгүүлсэн байна. Халимгийн ард

түмний соёл урлагийн уламжлал баруун Монголын соёлтой нягт холбоотой бөгөөд сүүлийн үед Халимагт хэл соёлоо сэргээх талаар ихээхэн анхаарч байгаа юм. Хязгаарлагдсан байсан Монгол Халимагийн харилцаа XX зууны эхнээс сэргэж байсан боловч Сталин болон түүнийг тойрон хүрээлэгчдийн улмаас зогсонги байдалд орсон. 60-70-аад оноос сэргэж эхэлсэн зэргийг “Монгол-Халимагийн харилцаа” гэсэн хэсэгтээ бичжээ.

Дөрөв дэх бүтэг нь Бүгд Найрамдах Тува Улс”. Үүнд, “Хүн амын гарал бүрэлдэхүүн хэсэг байна. Зохиогчийн бичсэнээр “урианхайчууд эрт дээр үеэс монгол нутаг дээр амьдарч байсан нүүдэлчин аймгуудын нэг болох нь тодорхой. Харин тэр нь орчин үеийн Тувагийн хүн амын ерөнхий нэр мөн үү, эсвэл түүний бүрэлдэхүүнд багтаж буй олон ястны нэг гэдгийг хэлэхэд бэрх юм” гэжээ. (т.84). Одоо Тувагийн 3000 гаруй мянган хүн амын гуравны хоёр нь монгол угсаатан, бусад нь орос болон хакасс, киргиз, уйгур зэрэг бусад үндэстэн ястан байна. (т.35). Дараа нь Тувагийн түүхэн тоймыг өгүүлэхдээ Оросын эрдэмтдийн бичсэн “Тувагийн түүх” номон дахь “XIII зууны эхээр Киргиз улсын бүрэлдэхүүнд байсан тувачуудыг Чингисийн цэрэг эзэлсэн”, “XIII зууны эхээр Тувад Монголын феодалуудын дарлал тогтов” гэсэн дүгнэлтүүд учир дутагдалтай болохыг тайлбарлаж бичжээ. (т.86). XX зууны эхээр үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд манай орон тусгаар тогтнолоо олсон үед Тувачуудын дунд хэл. Соёл, аж төрөх ёсны нийтлэг байдлыг харгалзан монголчуудтайгаа нэгдмэл байх. бас Хаант Оросын харъяанд орох гэсэн 2 янзын хандлага гарч байлаа. (.92). Хаант Орос алт болон бусад байгалийн баялгаар арвин, үржил шимт хөрс бүхий энэ нутагт колончиллын бодлогоо идэвхжүүлж байсан хэдий ч хууль зүйн үүднээс авч үзвэл энэ нутаг 1915 оны Орос, Хятад, Монгол улсын Хиагтын хэлэлцээрийн 11-р зүйлд зааснаар Гадаад Монголд харъяалагдаж байсныг зохиогч бичжээ. 1921 оны VII сарын 23-нд Бүх Тувагийн зохион байгуулах их хурлаар “Бүгд Найрамдах Тагна Тува Улс” байгуулах шийдвэр сэргэж анхдугаар үндсэн хуулиа баталсан үед Тувад байсан оросууд 1921 оны VII сарын 23-нд “Оросын өөрөө удирдах хөдөлмөрийн колонийн хязгаарын хувьсгалт хороо” гэгчийг байгуулсан нь Туваг Орост нэгтгэх гэсэн бодлогын үрэл байв гэсэн байна. (т.27). Цааш нь БНТува улс 20 гаруй жил оршин тогтнохдоо ЗХУ-ын тусламжаар эдийн засаг, соёлын салбарт үлэмжхэн амжилт олсныг бичжээ. 1944 онд Тува нь ЗСБНХУ ын бүрэлдэхүүнд дагаар орсон бөгөөд өнгөрсөн 50-иад жилд механикжсан хөдөө аж ахуй, уул уурхай, цахилгаан эрчим хүч голлосон үйлдвэр бүхий улс болсон байна. (т. 103). Соёл боловсролын салбарын хөгжилтийг мөн тодорхой бичжээ. 1991 онд тус улсын нэрнээс “Зөвлөлт Социалист Автономит” гэсэн тодотголыг хасч Бүгд Найрамдах Тува улс болгосон байна. Тус орон их гүрний түүхий эдийн хавсарга болж, бүх зүйлийг тэндээс авч байсан тул өнөөдөр зах зээлийн харилцаанд шилжиж буй нөхцөлд эдийн засгийн талаар биеэ даахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч буй аж.

“Монгол-Тувагийн харилцаа” хэсгийг бичихдээ Монгол Улсын намын түүхийн Архив. Улсын Түүхийн Тод Архив, Тува улсын архиваас судлан тун сонирхолтой материалууд ашигласан нь эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой болжээ. Мөн бүлгийн арын зүүлтэд БНТАУ-аас БНМАУ-д, БНМАУ-аас БНТАУ-д сууж байсан

элчин сайдуудын нэрсийг сууж байсан оны хамт жагсаасан байна.. Тал бүрийн салбарт өргөжин хөгжиж байсан Монгол Тувагийн харилцаа БНТАУ ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд орсноос хойш зогсонги байдалд оржээ. 70-аад оноос Увс, Завхан аймгууд Туватай шууд харилцаа тогтоож, соёл, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлж байна. Сүүлийн жилүүдэд ялангуяа хилийн худалдаа ихэд өргөжив.

“Бүгд Найрамдах Алтай Улс” гэдэг сүүлчийн бүлэгт урьд өмнө үзэл суртлын хүлээсийн улмаас энэ нутгийн суугуул оршин суугчид болох ойрадууд манай судлаачдын анхаарлын гадна орхигдсон байсныг зохиогч анх удаа монгол угсаатан болохыг бичиж түүхэн тойм, эдийн засгийн амьдрал, соёл гэгээрлийн талаар танилцуулж бичсэнээрээ цаашдын судалгаанд гараа болж өгөхөөс гадна, хоёр орны хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах эхлэл болж байна. Оросын зарим эрдэмтний ном зохиолд Алтайн ойрадууд 1756 онд Оросын харъянд орсон гэж байдгийг зохиогч Оросын баруун Монголыг судалсан эрдэмтэн Грумм Гржимайлогийн бүтээлээс иш татан няцаасан агаад XIX зууны II хагаст Оросын харъяанд орсон болохыг бичжээ. (т. 124). 1922 оны 1 сарын 1-нд Бүх Холбоотын Төвийн Гүйцэтгэх хорооноос ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд “Ойрадын Автономит муж”-ийг байгуулах шийдвэр гаргасан байна. (т. 125). И.В.Сталин болон түүнийг тойрон хүрээлэгчдийн таалалд уг нэр үл нийцсэн тул ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөл 1948 онд өөрчлөн “Уулын Алтайн автономит муж болгож, түүний төв “Ойрадын туурь” хотыг “Горно-Алтайск” гэж нэрлэжээ. (т. 125). Мөн уг угсаатны үндсэн “Ойрад” гэдэг нэр томъёо алга болж “Алтайчууд” гэх болсон нь үндэс угсаа, гарал үүслээ мартахад хүргэжээ. 1992 онд “Бүгд Найрамдах Алтай Улс” болсон байна. Хүн ам нь 198 мянга бөгөөд үүний 61 мянга нь ойрад угсаатан юм. (1989) (т. 123).

Зохиогч, тус улсын соёл гэгээрлийн талаар бичихдээ Алтайн хэл, соёл, түүх, ахуй, зан заншлыг судлахад их зүйл хийж байгааг дурдсан байна. Мөн “Уулын Алтай нутаг эртний хадны бичиг, хиргисүүр ихтэй бөгөөд тэндээс алт, мөнгөн эдлэл хувцас хунар, гэрийн тавилга зэрэг гар урлалын бүтээлүүд олдсон нь монгол судлалын тухал ач холбогдолтой юм” гэжээ.

Дашрамд хэлэхэд, зохиогч Монгол-Тувагийн харилцааны тухай өгүүлсэнчлэн ардчилал өрнөсөн 90-ээд оны өндөрлогоос Монгол ба ОХУ дахь Монгол угсаатан улсуудын хамтын ажиллагааг авч үзвэл, ололтын зэрэгцээ чамлалттай зүйлүүд байна. Бид эсгий туургатан нүүдэлчдийн нэг удам угсааны хувьд манай оронд ах дүү ард түмний амьдрал, түүхийг судлах, найрамдал, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх эх сурвалжийг судлан боловсруулах явдал үлэмж хоцрогдож иржээ. Ялангуяа эрдэмтдийн хамтын ажиллагаа, судалгаа тун ч чамлалттай түвшинд байна. Манай орон ба дээр өгүүлэгдсэн улсуудын хооронд эдийн засаг, нийгэм соёлын салбарт хамтран ажиллах ихээхэн бололцоо нөхцөл байна. Энэ эрхэм үйл хэргийн шинжлэх ухааны үндсийг боловсруулахад эрдэмтдийн хүчин чармайлт чиглэгдэх учиртай. Ингэж ажиллах нь ард түмнүүдийн эрх ашигт нийцэх болно. Миний бодоход, Орос дахь монгол угсаатан улсууд ном дээрх үйлсийн гараа болж өглөө.